

**ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН ЕБ-ЫН ХАН-УУЛ СУРГУУЛИЙН 8-Р
АНГИЙН МОНГОЛ ХЭЛ, БИЧГИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ**

Хугацаа: 60 минут
20

Хувилбар А

Нийт оноо

Монгол бөхөн

Монгол бөхөн нь буган биетэй, тэмээн толгойтой монгол хонины хэрийн биетэй ургамлан тэжээлт, хивэгч амьтан. Биеийн урт 100-145 см, сэрвээний өндөр 63-83 см, сүүл 8-13 см, чихний урт 7.5-11 см, жин 23-40 кг хүрнэ. Хөл, хүзүү нарийн, толгой том, өвөрмөц монхор хамартай, хамрын нүх маш том. Хэрэгчин мухар, хэржин 40 см хүрэх тунгалаг цайвар өнгөтэй хос шороон эвэртэй, эврийн цагирагт одорохой харагдана. Биеийн өнгө зуны улиралд бор шаргал байснаа өвөл болоход цайвар саарал болж өөрчлөгдөнө. Сэрвээнээс сүүлний уг хүртэл зоо дагасан нарийхан бор судалтай, хэвэл, гуяны дотор тал цайвар өнгөтэй.

Бөхөн нь Евроазийн том хөхтөн амьтдын дотроос устах аюулд нэлээд өртөөд байгаа зүйлийн нэг. Дэлхий дээр соргог бөхөн /*Saiga tatarica tatarica*/, монгол бөхөн /*Saiga tatarica mongolica*/ гэх хоёр салбар зүйлийн бөхөн бий. Эдгээр дэд зүйл нь амьдрах орчны хуваагдал, хууль бус гагнуур, гэрийн малтай бэлчээр, тархац нутгаар давхцах зэрэг шалтгааны улмаас 2 популяцын тоо толгой сүүлийн 20 гаруй жил /1980-2000/-ийн дотор 1 саяас 90000 болтлоо огцом буурсан байна /E.J.Miher-Guilard нар 2001/.

Монгол бөхөнг манай улсын төдийгүй олон улсын байгаль хамгааллын холбоод анхааралдаа авсаар ирсэн. Тухайлбал: Дэлхийн байгаль, байгалийн нөөцийг хамгаалах олон улсын холбооноос /IUCN, 2002/ гаргасан улаан номонд эмзэг гэсэн категорит, Зэрлэг амьтан, ургамлын ховордсон төрөл зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай олон улсын конвенцийн /Вашингтоны, CITES 1975, 1994/ II хавсралт буюу хатуу чанд хяналтан дор худалдаалах амьтдын жагсаалтад дэлхийн ховордсон 100 амьтны жагсаалтад тус тус бүртгэгдсэн. Монгол улсын хэмжээнд 1930 оноос эхлэн хуулиар агнахыг хориглон дархан цаазтай амьтны тоонд оруулсан. Монгол улсын “Улаан ном”-ын 1987, 1997 оны хэвлэл, 1995 оны шинэчлэн найруулсан “Амьтны аймгийн тухай хууль”-аар нэн ховор ангилалд оруулсан.

1. Хоёр дахь цогцолбороос бөхөнгийн ховордсон шалтгааныг бичээрэй. /2 оноо/

Бөхөнгийн ховордсон шалтгаан		
Амьдрах орчны хуваагдал		

2. Учир шалтгааны утгатай өгүүлбэрийг найруулж бичье. /2 оноо/

1. Тамхи нь их хэмжээгээр шүлс ялгаруулдаг. Тамхичин хүн байнга шүлсээ хаяж, гудамж талбайг бохирдуулдаг.

.....

2. Өглөөний нэг цаг өдрийн гурван цагтай тэнцдэгийг мэддэг. Эрт босдог.

.....

3. Үгийн утгыг тайлбарлая. /2 оноо/

Амжилт хүсье.

Хариулт

1	Хоёр дахь цогцолбороос бөхөнгийн ховордсон шалтгааныг бичээрэй.	хууль бус гагнуур, гэрийн малтай бэлчээр, тархац нутгаар давхцах
2	Учир шалтгааны утгатай өгүүлбэрийг найруулж бичье.	1. Тамхи нь их хэмжээгээр шүлс ялгаруулдаг учир тамхичин хүн байнга шүлсээ хаяж, гудамж талбайг бохирдуулдаг. 2. Өглөөний нэг цаг өдрийн гурван цагтай тэнцдэгийг мэддэг учраас эрт босдог.
3	Үгийн утгыг тайлбарлая.	Толгой нь эргэх -будилах, самуурах, төөрөх Ус балгасан юм шиг -дуугүй байх
4	Шалтгааны утгатай үгээс тохирохыг нөхөж бичээрэй.	1. Нэр хүндээ алдахгүйн тулд зарим доромжлолыг чимээгүй залгичих нь дээр. 2. Тайван цагт хөлс их гарах юм бол байлдааны цагт цус бага гарна.
5	Дараах үгсэд урт эгшгээр эхэлсэн нөхцөл залгаж, дүрмийг тайлбарлая	нөхөд-ийг-нөхдийг гийгүүлэгчээр төгссөн үгэнд урт эгшгээр эхэлсэн залгавар залгахад эцсийн гийгүүлэгчийн өмнөх балархай эгшиг гээгдэнэ. Анар-аас-Анараас Оноосон нэрийн төгсгөлийн гийгүүлэгчийн өмнөх балархай эгшгийг гээдэггүй.
6	Зохиолын эшлэлийг дүрслэх ур маягтай зөв харгалзуулаарай.	1В, 2А, 3Б, 4Д, 5Г
7	<p>kuclıyea ırde^ ı</p> <p>BO Zoeela</p> <p>Bsooa oa kEokEoa I</p> <p>I Degejo YeB.</p> <p>FBkEoa oa Sorgeeesea</p> <p>Kiedola.</p> <p>fe (T DeKO Ne* T</p>	Хөвгүүдийн эцэг эхийг ачилж, ах дүү нараа хүндэл. Өвгөдийн сургасныг дагаж яв. Бусдын хүүхдийг бүү шогло. Хичээн эрдмийг сурч, эрдэмт багшийг хүндэл.

**ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН ЕБ-ЫН ХАН-УУЛ СУРГУУЛИЙН 8-Р
АНГИЙН МОНГОЛ ХЭЛ, БИЧГИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ**

Хугацаа: 60 минут
20

Хувилбар Б

Нийт оноо

Хөвсгөл нуур

Хөвсгөл гэдэг үг нь түрэг хэлээр Көп Су Куп буюу “Их Устай Нуур” гэсэн үг юм. Монголчууд эрт дээр үеэс Ариг ус хэмээн нэрлэж байжээ. Хөвсгөл нуур нь Саяны нурууны зүүн хэсэгт байрлана. Өмнөд хэсэгт Эгийн гол эх авах бөгөөд Сэлэнгэ мөрөн цаашлаад Байгаль нууртай холбогдоно.

Долоон уул, Модотын шанаа, Салаа сарьдаг, Мэргэний үзүүр, Агьтын хошуу, Дээд, Доод модот булан, Марааны булан зэрэг нуурт түрж орсон хагас арал булантай. Модон хүй, Хадан хүй, Хүй толгой, Сома хад гэсэн 4 аралтай.

Хөвсгөл нуурын ай сав болох цоохор ирвэс, буданга хүдэр, зэрлэг цаа буга, ховор амьтан болох хүрэн баавгай, халиун буга, янгир ямаа, аргаль хонь, бараан хандгай, ойн булга зэрэг хөхтөн амьтад амьдардаг. Мөн умардын халиу, бор гөрөөс, зэрлэг гахай, нохой зээх, тарвага, чандага чоно, үнэг, хярс, мануул, дорго, зурам, хэрэм, солонго, цагаан үе, өмхий хүрэн, шилүүс, алаг даага зэрэг амьтад байдаг.

1. Эхэд юуг, яаж тайлбарласныг цогцолбор бүрээр тодорхойлъя. /2 оноо/

Бүтэц	Юуг тайлбарласан бэ?	Яаж тайлбарласан бэ?
Эхлэл		
Гол		
Төгсгөл		

2. “учраас, учир, тулд, улмаас, боловч” холбох үгээс тохирохыг сонгон “Эрт цагт оточ маарамбууд түүнийг түүж, эмийн сор болгон тунгаар хэмжиж, өвчин эмгэгт шаналагсдыг эмнэн тэнхрүүлдэг байжээ.” гэсэн өгүүлбэрийг шалтгааны утгатай нийлмэл өгүүлбэр болгон хувирган найруулна уу. /2 оноо/

3. Эхээс угсрах аргаар бүтсэн амьтны нэр 2-ыг олж бичээрэй. /2 оноо/

.....

4. Нийлмэл өгүүлбэрүүд хэрхэн холбогдсоныг ажиглаж, шалтгааны утга ямар хэлбэрээр илэрснийг тайлбарлаарай. /2 оноо/

Усан дуслыг хураавал сав дүүрнэ

Уран үгийг цуглуулбал мэргэн болно.

Тайлбар:

.....

5. “Цэцгээ тогтмол усалъя.” өгүүлбэрт орсон “**усалъя**” гэсэн үгийг үгийн бүтцээр задалж, “ь”-ийн үүргийг тайлбарлаарай. /2 оноо/

.....
.....
.....
6. Зохиолын нэрийг зохиолчтой нь харгалзуулна уу. /5 оноо/

- | | |
|-----------------|-------------------|
| 1. Хомер | А. Монгол хэл |
| 2. Ч.Ойдов | Б. Одиссей |
| 3. Б. Явуухулан | В. Далан худалч |
| 4. С. Дулам | Г. Тэхийн зогсоол |
| 5. Б. Ринчен | Д. Хүмүүн бичиг |
7. Эхийг уншаад кирилл бичигт хөрвүүлээрэй. /5 оноо/

сiлeгo cI сeсeйт
.
Hoлiлдоa
Forosi%Г.
сiлeгo Дeeйт
iie* iiea BУO
BPO, Si*Г,
Kикeт, ceгeа
Foлea. Foлeгeа,
Noгoгeа,

Амжилт хүсье.

Хариулт

1	Эхэд юуг, яаж тайлбарласныг цогцолбор бүрээр тодорхойлъё.	<p>Эхлэл-Хөвсгөл гэдэг үгийн тухай “Их устай нуур”, “Ариг ус” хэмээн нэрлэсэн.</p> <p>Гол- Хөвсгөл нуурын бүтцийн тухай Долоон уул, Модотын шанаа, Салаа сарьдаг, Мэргэний үзүүр, Агьтын хошуу, Дээд, Доод модот булан, Марааны булан зэрэг нуурт түрж орсон хагас арал булантай. Модон хүй, Хадан хүй, Хүй толгой, Сома хад гэсэн 4 аралтай.</p> <p>Төгсгөл- Хөвсгөл нуурын ай савын тухай Ямар ямар амьтад амьдардгыг бичсэн.</p>
2	“учраас, учир, тулд, улмаас, боловч” холбох үгээс тохирохыг сонгон, өгүүлбэрийг шалтгааны утгатай нийлмэл өгүүлбэр болгон хувирган найруулна уу.	Эрт цагт оточ маарамбууд түүнийг түүж, эмийн сор болгон тунгаар хэмжиж байсан учир өвчин эмгэгт шаналагсдыг эмнэн тэнхрүүлдэг байжээ.
3	Эхээс угсрах аргаар бүтсэн амьтны нэр 2-ыг олж бичээрэй.	хүрэн баавгай, халиун буга, янгир ямаа, аргаль хонь, бараан хандгай, ойн булга
4	“Цэцгээ тогтмол усалъя.” өгүүлбэрт орсон “усалъя” гэсэн үгийг үгийн бүтцээр задалж, “ь”-ийн үүргийг тайлбарлаарай.	усал-я , “ь” тусгаарлах үүрэгтэй
5	Тодруулсан үгийг бүтцээр задалж, зөв бичих дүрмийг тайлбарлаарай.	Орхоны: Орхон-ы Оноосон нэрийн төгсгөлийн гийгүүлэгчийн өмнөх балархай эгшгийг гээдэггүй.
6	Зохиолын нэрийг зохиолчтой нь харгалзуулна уу.	1Б, 2В 3Г, 4Д, 5А
7	<p style="text-align: center;"> c1Lego c1 cecceit . HOLLIDOA FOrosi%T. c1Lego Deeit iie* iiea BУO Bro, si*T, Kiket, cegea </p>	Нутаг чулууны өнгө тоолж баршгүй олон. Улаан, ногоон, бор, хөх, цагаан чулуу дангаараа буюу холилдон оршино. Чулуу чи цэцэг.

Амжилт хүсье.